

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 04 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

Дугаар	ХБТББ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая төг)	Төсвийн гүйцэтгэл (сая төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	4.1.1.11.Визийн зөрчилтэй гадаад иргэдийн тоог бууруулж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	2024-2028	Хууль зүй, дотоод хэргийн яам	Улсын төсөв	-	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр 40 ¹ дүгээр зүйл (Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан)-ийг нэмсний дагуу “Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системийг нэвтрүүлэх арга хэмжээг 2022 онд Хууль	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна. (ЗГҮАХХА ХТ 2020-2024-ний 2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт)	-	0.0	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр “Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системийг үйл ажиллагаанд нэвтрүүлж, гадаадын иргэний визийн зөвшөөрөл, виз, оршин суухтай холбоотой мэдээллийг бүртгэх, хяналт тавих, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг шуурхай хангах боломжийг бүрдүүлсэн. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн мэдээлэлд бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна. Гадаадын иргэн, түүний уригчийг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор виз болон оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусаж байгаа иргэдийн мэдээллийг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-аас уригч байгууллага, гадаадын иргэний бүртгэлтэй утсанд цахим хэлбэрээр өгөх, хугацаа хэтэрсэн бол гадаадын иргэний хяналтын	100

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
							зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын “Тоног төхөөрөмж” багцаас 470.0 сая төгрөгийн санхүүжилтээр ашиглалтад оруулсан.				улсын байцаагч хуульд зааснаар зөрчил шийдвэрлүүлэх талаар уригч, гадаадын иргэнд мэдэгдэх, гадаадын иргэн улсын хилээр нэвтэрснээс хойш 48 цагийн дотор бүртгүүлэх, хаяг, байршлаа өөрчлөх бүрд 48 цагийн дотор бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. Гадаадын иргэнд хяналт тавих зорилгоор 1 дүгээр улиралд төлөвлөгөөт 12, төлөвлөгөөт бус 54 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчил гаргасан нийт 2810 гадаадын иргэн (хувь хүнээр зөрчил гаргасан 435, уригч иргэнээр зөрчил гаргасан 9, уригч хуулийн этгээдээр зөрчил гаргасан 2366)-д торгох шийтгэл ногдуулан, 215 гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргалаа. https://opendata.gov.mn/ “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг ашиглалтад оруулснаас хойш 845 удаагийн засвар, шинэчлэлийг хийж, хөгжүүлэлтийг сайжруулан визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, оршин суух зөвшөөрлийн хэлбэр өөрчлөлт, паспортын мэдээлэл өөрчлөлт, оршин суух зөвшөөрлийн хаягийн өөрчлөлт, оршин суух үнэмлэх дахин авах, гадаадын иргэний бүртгэлтэй холбоотой нийт 71,197 хүсэлтийг хүлээн авсан ба үүнээс 20,289 хүсэлтийг 1 дүгээр улиралд хүлээн авч тус тус хянан шийдвэрлэлээ. Системийн санхүүжилтийг 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шийдвэрлэсэн бөгөөд 2025 оны 1 дүгээр улиралд хөгжүүлэлтэд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.	
Үнэлгээ 100 хувь												